




## 1.7. Нөлөөллийн ажлаа яаж хийсэн бэ?

Мониторингийн хамгийн гол үйл ажиллагаа нөлөөлөл юм. Нөлөөллийн үйл ажиллагааны амжилтын эх нь нөхцөл байдлын бодитой үнэлгээ, батлах баримт нотолгоо зөрчлийг хэрхэн засаж залруулах талаар гүйцэтгэх боломжтой шийдэл зэрэг байдаг.



Төрийн байгууллагаас боловсруулан хэрэгжүүлж буй бодлого, иргэдэд хүргэж буй үйлчилгээ, үйл ажиллагаанд илэрсэн алдаа дутагдал, зөрчил гажуудлыг ямар хөшүүрэг, арга хэрэгсэл ашиглан сайжруулж болох талаар зорилго тавин, төлөвлөгөө боловсруулж, тодорхой стратегид тулгуурласан үйл ажиллагаа явуулахыг нөлөөлөл гэж ойлгоно.



“Үдийн цай” хөтөлбөрийн хэрэгжилтэнд мониторинг хийж, зөвлөмж л өгснөөр хэрэгжилт нь сайжирна гэж төсөөлөхөд хүнд байсан учраас төсөл хэрэгжүүлэх явцдаа нөлөөллийн ажлуудаа давхар хийж, гарсан зөрчил, дутагдлыг олон нийтийн анхааралд хандуулж, эцэг эхийн болон багш, хүүхдүүдийн дэмжлэгийг авч ажиллахад гол анхаарлаа хандуулсан.





## Мониторингийн үе шатууд:



**МОНИТОРИНГ**  
Судалгаа  
Үр дүнг мэдээлэх  
Нөлөөлөл  
Эрэг үр дүн

## СУДАЛГАА

1. Мониторинг хийх асуудлыг сонгох
2. Суурь судалгаа
3. Мониторингийн аргачлал
4. Мониторинг хэрэгжүүлэх
5. Тайлан бичих
6. Нөлөөлөл

## ҮР ДҮНГ МЭДЭЭЛЭХ

- Төслийн үйл ажиллагаа бүрийг олон нийт, болон мэргэжлийн байгууллагуудад хүргэх
- Орон нутгийн сонингоор мэдээлэх
- Телевизээр мэдээлэх
- Хэлэлцүүлэг
- Уулзалт
- Боловсрол суваг ТВ-ийн нэвтрүүлэг

## НӨЛӨӨЛӨЛ

- Танин мэдэхүйн сургалт
- 3 талын оролцоотой ТВ-ийн хэлэлцүүлэг
- БСШУЯамтай хийсэн уулзалтууд
- Бизнесийн зөвлөгөөнд мэдээлэл хийсэн
- Зөвлөмж боловсруулсан
- Боловсрол суваг телевизийн нэвтрүүлгүүд



### “Удийн цай” хөтөлбөрийн талаарх дээгэрэнгүй мэдээлэл

“Удийн цай” хөтөлбөр өмнө хэрэгжүүлэгч багш нарын анхааралд...

**“Удийн цай” хөтөлбөрийн хаанаас санаа орсонд вэ?**

Удийн цайнд зориулсан мөнгийг Монгол Улсад хөгжүүлэх сангийн Монгол банкн дала Хуудс гар бүхий хөгжүүлэх хөтөлбөрөөс сан хуудсад Энэ хөтөлбөрийг хэрэгжүүлэх зориулсан мөнгө эвчэн хүүхдийн үдийн цайны хоол, хүнсэнд зориулагдах ёстой. Нэг хуудад өдөрт бүтээгдүүний үнэ 400 төгрөг байгаар шинэчлэн тогтоосон. Төний өнг 30 хуудадтай бол өдөрт 12000 төгрөгийн, сард 240000 төгрөгийн жинд төгрөгийн бүтээгдүүнийг авч байгаа. Ангийн багш хүүхдийн ирцийг нарийн бүртгэж, нийлүүлэгч байгууллагаас өгч байгаа бүтээгдүүнийг авч чанар, үндэс хяналт тавих нь оролцоог нэмэгдүүлнэ.

**БСШУЯ-ны сайд Э.Орullo Мэндийн** сайдын 378341 тоот хянгараас тухайлаас Удийн цайнд олгох хүүсний бүтээгдүүлд тавих шаардлага.

3.1 Хүүсний эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангасан байна.

3.2 Гэрээт гүйцэтгэгчээс нийлүүлж буй нөөцөд сан, багшаа боогдтой, шогштой байна.

3.3 Амни дэм, эрдэс борлоосор баяжуулсан бүтээгдүүн байх

3.4 Бүтээгдүүнд гүнд итгэмжлэгдсэн шинжлэлийн байгууллагаар дүгнэлт гаргуулна.

“Удийн цай” хөтөлбөрт хэн хяналт тавих вэ?

6.1. Удийн цай хөтөлбөрийн хэрэгжилтэд аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн болон Боловсрол соёлын газар, мэргэжлийн хяналтын байгууллага хяналт тавина.

6.2. Сургуулийн үдийн цайны үйлчилгээнд тухайн сургуулийн эмч/мэчлэгч сургуулийн хувьд бага өнгийн сургалт хариуцсан эмч/өмчийн аргаар өдөр тутмын хяналт тавих ажиглана.

6.3. Сургуулийн эмч, мэчлэгийн эрхлэгчээс дарах ажлыг хийж гүйцэтгэнэ.

6.3.1. Талуудын гэрээний хэрэгжилтэд байнгын хяналт тавих, гэрээг дүнхэж захирлын дэргэдэх зөвлөлд танилцуулах

6.3.2. Шаардлага хангахгүй бүтээгдүүнийг буцаах.

6.3.4. Анги урдирдсан багшар дамжуулан шим тэжээлийн борис ба зөв хооллох дэглэмийн талаар суралцагчдад сургалт явуулах, ажиг үйлчилгээг өгөх

6.3.5. Удийн цайны өмнө анги танхимын ариун цэвэр, сургагч бүрийн гэрээ гэрээлэх буй эсэхэд хяналт тавих.

6.3.6. Таргалалттай болон жин багадаалттай хүүхдэд онцгойлон анхаарал тавих ажлыг өмчийн эмч/агч хяналт тавих, гэрээг заргалт дутаагыг тухай бүр нь ариунгуулж, ажиглах

6.4. Удийн цайны үйлчилгээнд сургуулийн бага өнгийн эдийн засгийн хяналтын комисс “Хяналтын комисс” хяналт тавина.

6.5. Хяналтын комиссоос хөтөлбөрт багтсан хуваарийн дагуу үдийн цайны үйлчилгээний чанар дараах чиглэлээр хяналт тавина.

6.5.1. Удийн цайнд олгож буй хүүсний бүтээгдүүн эрүүл ахуйн шаардлага хангаж буй эсэх

6.5.2. Анги танхимын ариун цэвэр болон суралцагч нарыг уявгаж, буй эсэх

6.5.3. Хүүхдийн дур сонирхол, эрүүл мэндэд тохирч буй эсэх

6.5.4. Цагтаа орж буй эсэх

6.5.5. Дэмж бөгөөд өмч буй эсэхэд хяналт тавих


6.5.6. Удийн цайны үйлчилгээнд хяналт тавихан ахлуулсан “Хяналтын комисс” гишүүд үр дүнг сургуулийн ажиралд тухай бүр танилцууна.

6.7. Удийн цайны үйлчилгээний талаар сургуулийн ажиргааг уявгаж, нэг удаа өдөр эхэд танилцуулж санал бодлыг тусгана.

6.8. Сургуулийн захирал аймаг, нийслэлийн Боловсролын газраас Удийн цай хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг уяврал бүрийн эцэст гаргаж, Боловсрол соёл шинжлэх ухааны яаманд танилцуулна.

6.9. Удийн цайны үйлчилгээг шаардлагын хэмжээнд зохион байгуулагдах үүхдийн эрх шийдлийн хөтөлбөр нь эрх бүхий байгууллагын шалгалтаар нотлогдсон байгууллага болон албан тухайланг Боловсролын тухай хууль, бусад хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлнэ.


Д.Мянгароо







Нөлөөлөл хийхэд хамгийн чухал, нийтлэг ямар асуудал байгааг тодруулж, тал бүрийн оролцоог хангахад анхаарах, үг бүр үнэтэй байхыг чухалчлах хэрэгтэй байдгийг төслийн явцад олж харсан. Мэдээллийг харьцуулах маягаар гаргах нь сайн нөлөөтэй байлаа.

Ер нь төрийн байгууллагад ажиллаж байгаа хүмүүс өөрийгөө магтуулах дуртай байдаг учир сайн талыг нь эхэлж сайшааж, харилцаагаа сайжруулах замаар анхны алхмаа тавьж, цаашид гарч буй зөрчлийг арилгах, сайжруулах руу чиглүүлэн нөлөөлөл хийж байсан. Тийм учраас сургуулиудын сайн тал, хандлагыг харьцуулан жишиж асуудал, мэдээллээ олж авч байсан.

 Аливаа мэдээллийг тухайн байгууллага, холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, хүлээн зөвшөөрүүлсний дараа олон нийтэд цацах хэрэгтэй. Учир нь ямар нэгэн баталгаагүй мэдээлэл цацагдах, хүмүүст ташаа ойлголт төрүүлэх зэргээр алдаа гаргавал “тухайн төрийн байгууллагуудаас өөрсдийгөө хамгаалах няцаалт хэзээд бэлэн байдаг” бөгөөд энэ нь төслийн хүрэх үр дүн, олон нийтэд нөлөөлөх байдал зэрэгт мүү үр дагавар авч ирэх аюултай байдаг. Төслийн хугацаанд БСГ, ЕБС-ийн захирлуудтай байнга холбоотой ажилласан.





### НӨЛӨӨЛӨЛ ХИЙХ АРГУУД:

1. Эрх зүйн бодлогын шинэчлэл хийх
2. Засгийн газарт шууд лобби хийх
3. Албан бичиг илгээх
4. “Тэргүүн нүүрний мэдээ” бичих
5. Төр засагт хүлээсэн үүргийг нь сануулах, шахалт үзүүлэх
6. Дугуй ширээний уулзалт хийх
7. Хэлэлцээрийн ширээнд урьж, үр дүнтэй түншлэл тогтоох
8. Шийдвэр гаргагчидтай ганцаарчлан уулзах
9. Хэвлэл мэдээллийн хэрэгслийг татан оролцуулах
10. Хэвлэлийн бага хурал хийж, бодит баримтыг олон нийтэд дэлгэх
11. Иргэдтэй уулзаж, тэдний дэмжлэгийг авах
12. Сургалт зохион байгуулах
13. Олон нийтийн санал асуулга явуулах
14. Мэдээлэл харилцааны технологийг хэрэглэх /вэбсайт, гар утсаар мессеж, электрон шуудан/
15. Үзэсгэлэн худалдаа зохион байгуулах



Бид эдгээр олон аргуудаас тухайн нөхцөл байдалд тохируулан байгууллагуудад албан бичиг илгээх, төрийн албан хаагчдад хүлээсэн үүргийг нь сануулах, иргэдтэй уулзах, тэдний дэмжлэгийг авах, шийдвэр гаргагчидтай ганцаарчлан уулзах (сургуулийн захирал, БСГ-ын удирдлага, мэргэжилтнүүд), хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглах, олон нийтийн санаа бодлыг утсаар авах, санал асуулга явуулах, сургалт зохион байгуулах, сонинь мэдээ нийтлэх зэрэг аргуудыг орон нутгийн түвшинд боломжтой бүхий л хувилбараар ашиглаж байлаа.





Нөлөөллийн ажлын хамгийн үр дүнд хүрсэн гол зүйл нь “Үдийн цай”-ны асуудлаар гарсан асуудлуудын хүрээнд зохион байгуулсан үе шаттай хэлэлцүүлгүүд байлаа. Эдгээр хэлэлцүүлгүүдээр асуудлыг танилцуулж, саналыг авч, тодорхой хэмжээний санал, зөвлөмжүүд гаргаж байсан. Эцсийн хэлэлцүүлгийг “Арвайхээр чөлөөт суваг” телевизээр шууд дамжуулж, олон нийтийн саналыг утсаар авч, нэгдсэн дүгнэлт гаргасан.

### 1.8. Хэвлэл мэдээлэлтэй хэрхэн ажилласан бэ?

Мониторингийн төслийг хэрэгжүүлэхэд хэвлэл мэдээллийн байгууллагатай эхнээс нь хамтарч ажиллахыг чухалчлах нь иргэд, олон нийт, ашиг хүртэгч нарт төслийн зорилго, үр дүнг ойлгуулах маш их үр нөлөөтэй байсан.

Үйл ажиллагааны үе шат бүрт аймгийн телевизээр мэдээлэл өгч байсан. Телевизийг богино хугацаанд олон хүн үздэг учраас мэдээлэл олон хүнд хүрч, төслийн богино хугацаанд үр дүн гаргахад сайнаар нөлөөлсөн.

